



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 ёдөр

Дугаар A/27

Хараат

Г Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, “ж”, “л”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн A/339 дүгээр захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан, шинэ коронавирус (КОВИД-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд соёл, урлаг, спорт болон олон нийтийг хамарсан бүх төрлийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд түр хориглосугай.

2. Сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 1-ний 06:00 цаг хүртэл хугацаанд түр зогсоосугай.

3. Архи, согтууруулах ундаа худалдах, борлуулахыг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд түр хориглосугай.

4. Хот, аймаг, сум хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд түр хориглосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын нийт бүрэлдэхүүн, Засаг даргын Тамгын газар (З.Солонго), Цагдаагийн хэсэг (Б.Азжаргал), болон холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БУДЖАВ

